

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2023 – 03 САР | ДУГААР 52

ГАРЧИГ

2–4	Бодлогын нийтлэл
5–7	Зохицуулалтын мэдээ
8–10	Байр суурь
11	Тайлбар ба зөвлөмж
12	Санхүүжилт татах ногоон бүтээгдэхүүнүүд
13–14	Иншуртек ба өнөөгийн нөхцөл байдал
15–21	Судлаачийн индэр
22–23	Компанийн засаглал, комплайнс
24–25	Санхүүгийн боловсрол
26–27	Олон улсын зах зээлийн мэдээ
28	Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ХӨГЖИЛД ГИШҮҮН БҮР МЭДЛЭГ, УР ЧАДВАР, ТУРШЛАГАА ОРОЛЦУУЛЖ, ХЯНАЛТАА ТАВИХ НЬ ЧУХАЛ



Хадгаламж, зээлийн хоршооны салбарт (цаашид “ХЗХ” гэх) Азийн Хөгжлийн Банкаас хэрэгжүүлж буй ТА 9654–МОН: “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн үндэсний зөвлөх Т.Оюунчимэгтэй төслийн талаар болон хадгаламж, зээлийн хоршооны салбарын хөгжлийн талаар ярилцлаа.

Тэрээр 2005 онд Канадын хоршоодын холбооноос хэрэгжүүлсэн ХЗХ–дыг чадавхжуулах төсөлд ажиллаж эхэлснээс хойш Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг санхүүгийн байгууллагуудаас гадна НҮБХХ, ШХА, АНУОУХА, ГТХАН, ДБХС зэрэг олон улсын 10 гаруй байгууллагатай хамтран тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгийг төрөлжүүлэх, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлж чадавхжуулахад ХЗХ–ны онцлог давуу талыг ашиглан орон нутагт хөгжүүлэх тал дээр ажиллаж байна.

Сайн байна уу, ХЗХ–ны онцлогийн талаар яриагаа эхлэх үү?

ХЗХ нь олон улсад тогтсон зарчмуудтай, хаана ч хөгжүүлж болдог, санхүүгийн салбартаа тухайн үндэстний өөрсдөө хянаж удирддаг, хэнээс ч хамааралгүй бие даан хөгжиж чаддаг, иргэдийн санхүүгийн боловсрол, ирээдүйн орлого, амьжиргаа, бизнес эрхлэлтийг дэмждэг том бүтэц болж хөгждөг ийм салбар. Тус салбарыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байгаагаараа бахархдаг.

Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулснаар ямар үр өгөөж бий болох вэ?

Юун түрүүнд бичил санхүү гэдэг ойлголтын талаар товчхон дурдах нь зүйтэй байх. Бичил санхүү гэж орлого багатай иргэдэд санхүүгийн үйлчилгээг хүргэх арга хэлбэр юм. Нобелийн шагналт эдийн засагч Мухамед Юнус 1980–аад оны дундуур ХЗХ–ны давуу тал, онцлог дээр суурилан энэхүү концепцыг гарган Энэтхэгт Грамеен банкыг байгуулж байсныг дэлхий дахинаа мэднэ. Ойролцоогоор өдөрт 2.0 ам.доллараас бага орлоготой буюу манайхаар сард 200.0 мянга орчим төгрөгөөс бага орлоготой иргэдэд санхүүгийн боловсролыг олгох замаар зээл, хадгаламж, даатгал зэрэг албан ёсны санхүүгийн үйлчилгээг хүргэж, хүртээмжийг нэмэгдүүлж байдаг. Өөрөөр хэлбэл, иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар найдвартай харилцагч болгон бэлтгэдэг. Хэрэв орлого багатай, эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн боловсролын хамт санхүүгийн байгууллагын хэрэглэгч болгож чадахгүй бол өндөр хүүтэй зээл өгдөг хувь хүмүүсээс өндөр хүүтэй зээл авч, амьжиргаа нь улам хүндэрдэг, улмаар ядуурал улам гүнзгийрдэг.

Үргэлжлэл 8–р нүүрт



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ӨМЧ ХУВЬЧЛАЛ

Өмч хувьчлал нь өмч хөрөнгийг улсын салбараас шилжүүлэх үйл явц бөгөөд энэ тодорхойлолтоос харахад улсын салбарын удирдлагын хэсэг биш юм. Үүний зэрэгцээ өмч хувьчлал тусгай журам, ур чадвар, мэдлэг шаарддаг учраас олон талаар өөрөө бие даасан салбар.



PRIVATIZATION

Privatization is the process of moving assets out of the public sector, and by definition is not part of the management of the public sector. Moreover, privatization entails special processes, skills, and considerations, and is in many ways a separate area in its own right.

Эх сурвалж: Сэндбокс зохицуулалтын орчны журам



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2022 оны жилийн эцсийн байдлаар 6.89 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.2 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд нийт 594.85 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн бөгөөд үүнээс 343.4 тэрбум төгрөг буюу 57.73 хувийг хувьцаа, 134.06 тэрбум төгрөг буюу 22.54 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 103.75 тэрбум төгрөг буюу 17.45 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 13.62 тэрбум төгрөг буюу 2.29 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус бүрдүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлд гарч буй өсөлт, амжилтыг хэвээр хадгалах, иргэдийн хөрөнгийн зах зээл дээрээс хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч, аж ахуй нэгж, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын идэвх, сонирхлыг өсгөх, олон нийтэд санал болгон хувьцаа, компанийн бонд гаргахтай холбоотой зардал, өртөг, хугацааг бууруулах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, олон улсын зохицуулалтыг нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах бодлого, зохицуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүллээ:

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль: Улсын Их Хурлаас уул уурхайн бүтээгдэхүүний үнийг шударгаар тогтоох, борлуулалтыг

нээлттэй, зах зээлийн зарчимд нийцсэн байдлаар хийх зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспортын арилжааг ил тод, нээлттэй болгох зорилгоор Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсантай холбогдуулан нүүрсний цахим арилжааг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан хийхийг Засгийн газарт, цахим арилжаанд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хороонд даалгасан. Түүнчлэн “Засгийн газрын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор нүүрс экспортлогч аж ахуйн нэгжийн экспортод гаргах нүүрсийг цахимаар нээлттэй арилжих үйл ажиллагааг зохион байгуулах, түүнтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ыг баталсан билээ. Уг журмын хэрэгжилтэд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавихаар зохицуулсан.

Санхүүгийн зохицуулах хорооноос “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаанд тавих хяналтын журам”-ыг 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран баталж, экспортод гаргах нүүрсний цахим арилжаанд хяналт тавин ажиллаж

байна. Тус журам батлагдсанаар уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа шударга, нээлттэй ил тод зохион байгуулагдахад чухал ач холбогдолтой юм.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь биржийн болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах нөхцөл, шаардлага, үйл ажиллагаанд хяналт тавих, биржийн арилжааны төлбөр, тооцоо хийх харилцааг зохицуулсан нэр бүхий журмуудыг баталж, зохицуулалтын орчныг тодорхой болгох үүрэг хүлээнэвч гадна геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх журам баталж мөрдүүлэх юм.

Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос нүүрсний цахим арилжаатай холбоотойгоор арилжаа зохион байгуулагч болох “Монголын хөрөнгийн бирж” ХК, мөн нүүрс худалдагч талуудтай хамтран ажиллаж, холбогдох чиглэл, саналыг тогтмол өгч ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль: Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн төслийг баталсан. Тус хуулиар хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк байгуулах, зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны эрхлэх үйл ажиллагааны

хүрээ, удирдлага, зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулсан болно. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуульд заасан хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл олгох, үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хязгаарлалт, зохистой харьцаа, хяналт шалгалттай холбоотой журам боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулагдсан бөгөөд уг ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл орон ажиллаж байна. Тус ажлын хэсгээс нэр бүхий журмуудын төслүүдийг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасны дагуу нэр бүхий журмын төслүүдэд олон нийтээс санал авч байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль: Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчин шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон тус хуулийг дагалдан өргөн баригдах Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлэн эцэслэн боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд 2023 оны Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлж, батлуулахаар ажиллаж байна.



Төрийн өмчит компаниудын хувьчлал: Төрийн өмчит хуулийн этгээдийг нэмж хувьцаа гаргаж биржээр нээлттэй арилжаалах замаар олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах зорилгоор Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022–2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл”-ийг баталсан. Үүнтэй холбогдуулан Засгийн газраас 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 244 дүгээр тогтоолоор “Төрийн мэдлийн хувьцааг 2022–2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-ыг баталсан бөгөөд уг жагсаалтад “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Үндэсний давхар даатгал” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Мэдээлэл, технологийн үндэсний парк” ТӨҮГ болон бусад 20 АЗЗА багтсан. Энэ хүрээнд “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь төрийн өмчит бусад компаниудыг түүчээлэн хамгийн эхэнд нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээний нэмж гаргах хувьцааг Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 690 дүгээр тогтоолоор бүртгэсэн.

Банкны салбарын реформ хэрэгжиж байгаатай зэрэгцэн нэр бүхий төрийн өмчит хувьцаат компаниудыг хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах ажиллагааг амжилттай хэрэгжүүлснээр компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал сайжирч, олон улсын жишгийн дагуу мэргэжлийн хөрөнгө оруулагчид удирдлагын багыг хэрэгжүүлж үйл ажиллагааны ашиг орлогыг нэмэгдүүлэх, улмаар гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чухал ач холбогдолтой юм.

Биржийн бус зах зээлийн журам: Биржийн бус зах зээл дээрээс дотоодын аж ахуйн нэгжийн санхүүжилт татах сонирхлыг улам нэмэгдүүлж, үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулж, түүнтэй холбоотой гарах зардал, өртөг, хугацаа багасгах чиглэлийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс холбооны “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулгыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 17 дугаар тушаалаар батламжилсан бөгөөд уг шинэчилсэн журмаар холбооны бүртгэлийн хороо нь үнэт цаас гаргагчаас ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг хянаад нэмэлт баримт бичиг шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд ажлын 3 хоногт багтаан бүртгэлийн хорооны хуралд оролцох гишүүдэд холбогдох баримт бичгийг хүргүүлэх, үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт материал шаардлагатай бол үнэт цаас гаргагчид нэмэлт материал шаардсан үндэслэл, шалтгааныг

хүсэлт гаргагчид тайлбарлах, үнэт цаасны төрлөөс хамааруулан санхүүгийн хэрэгсэлд тавих шаардлага зэргийг нарийвчлан тусгасан болно. Дээрх журмын зохицуулалтын үр дүнд үнэт цаас гаргагчийн хаалттай өрийн хэрэгсэл гаргах ажиллагаа хялбар шуурхай болж, түүнд шаардагдах хугацаа багасгах, зардал, өртөг буурах зэрэг эерэг нөлөөг биржийн бус зах зээлд бий болгох давуу тал бүрдсэн. Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс 2022 оны жилийн эцэс хүртэлх хугацаанд биржийн бус зах зээлд нийт 61 үнэт цаас гаргагчийн нийт 1.42 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 78 компанийн бонд гарсан бөгөөд 946.5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн байна.

Банкны салбарын реформ: Улсын Их Хурлаас Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2021 онд баталсан нь арилжааны банкуудад зохистой засаглалыг бий болгох, олон нийтийн хяналттай, нээлттэй, ил тод банкны салбарыг бүрдүүлэхэд томоохон түлхэц болох төдийгүй зөвхөн банкны салбар бус нийт санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, нэн ялангуяа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой шийдвэр болсон.

Банкны реформыг хэрэгжүүлснээр банкны үйл ажиллагаа ил тод, нээлттэй болж, хяналтын тогтолцоо илүү боловсронгуй болох, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөж, чанартай, хөрвөх чадвар өндөр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо нэмэгдэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх, оролцоо сайжрах, банкуудад урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр бий болохоос гадна олон тулгуурт санхүүгийн тогтолцоог бий болгоход чухал алхам болох юм. Одоогоор Монгол Улсад нийт 5 системийн банк /Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Төрийн банк, Хас банк, Голомт банк/ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс “Төрийн банк” ХХК нээлттэй хувьцаат компани болох ажлыг түүчээлэн эхлүүлж, анхдагч зах зээлд хувьцааны арилжааны захиалга нь 100 хувийг давж, хөрөнгө оруулагчдаас санхүүжилтээ амжилттай татан төвлөрүүлсэн. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 634 дүгээр тогтоолоор “Голомт банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэсэн бөгөөд тус банк нь нийт гаргасан хувьцааныхаа 10.09 хувь буюу 80,402,743 ширхэг хувьцааг 1,285 төгрөгөөр олон нийтэд санал болгож, олон нийтээс 103.3 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн нь нээлттэй хувьцаат компани болсон банкны системд нөлөө бүхий хоёрдахь банк болсон. Түүнчлэн, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 689 дүгээр тогтоолоор “Хаан банк” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэсэн.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГАА ЭХЛҮҮЛЛЭЭ



Хүнсний үйлдвэрлэлийн салбарт 24 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа “Газар шим үйлдвэр” ХХК-ийн олон нийтэд санал болгон гаргаж буй хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх цан цохих ёслол өнөөдөр боллоо. Ёслолын арга хэмжээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Бизнес хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ, “Газар шим үйлдвэр” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Ганбат, “Новел инвестмент ҮЦК” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Ангар болон бусад хүмүүс оролцсон юм.



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Сүүлийн жилүүдэд дотоодын хөрөнгийн зах зээл идэвхжихийн зэрэгцээ жил ирэх тусам ДНБ-тэй харьцуулсан дүн өссөөр байна. Энэ нь Хорооноос баримталж буй бодлого болоод дэд бүтцийн байгууллагууд, мэргэжлийн оролцогчид хоорондын уялдаа холбоо, зохицуулалт үр дүнтэй байсны илрэл гэж харж байна. Бидний хувьд аж ахуйн нэгжүүдэд

IPO, компанийн бонд гаргах замаар хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах бололцоог нэмэгдүүлэхээр “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталж, олон улсын жишигт нийцүүлэн, үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулсан. Ингэснээр зөвхөн сүүлийн хоёр жилийн хугацаанд гэхэд дотоодын аж ахуйн нэгжүүдээс нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах буюу IPO хийх замаар хөрөнгийн зах зээлээс урт хугацааны санхүүжилт татах сонирхол эрс нэмэгдсэн. Харин энэ оны анхны IPO-г үндэсний томоохон үйлдвэрлэгч “Газар шим үйлдвэр” ХХК-аас эхэлж байгаад баяртай байна. Дотоодын хүнсний үйлдвэрлэл тэр дундаа импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих УИХ-ын тогтоолын хүрээнд тарифын зохицуулалт хийх замаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын хамаарлыг бууруулах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг ач холбогдол бүхий шийдвэрүүдийг манай улс шат дараатайгаар хэрэгжүүлж байна. Энэхүү үйл ажиллагаанд нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн гаргахаар тус компани эхлэлийг тавьж байгаад дахин баяр хүргэе” хэмээн онцолсон юм. “Газар шим үйлдвэр” ХХК нь нийт хувьцааныхаа 16.54 хувь буюу нэг бүр нь 53.0 төгрөгийн үнэ бүхий нийт 198.0 сая ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож зах зээлээс 10.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөжээ.

ДААТГАГЧ НАР ТЕНДЕРИЙН БАТАЛГАА ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦОНО





Даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад Улсын Их хурлаас өнгөрсөн оны 12 дугаар сард нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэснээр даатгалын компаниуд холбогдох этгээдээс бусад этгээдэд баталгаа, батлан даалт гаргах, төрийн худалдан авах ажиллагаанд даатгалын компанийн гаргасан баталгааг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь энэ оны нэгдүгээр сарын 31-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Тодруулбал журмаар даатгалын компани баталгаа гаргах тохиолдолд санхүү, төлбөрийн чадвар болоод удирдлага, зохион байгуулалтын хувьд ямар шаардлага тавигдах, хэдий хэмжээний баталгааг гаргаж болох, үүсч болзошгүй эрсдэлээс хэрхэн сэргийлэх зэрэг харилцааг зохицуулж байна. Хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр мөрдөгдөж, түүний хэрэгжилтийг хангахад шаардлагатай зохицуулалтын журам батлагдсанаар даатгалын компаниудын баталгаа гаргах хууль эрх зүйн орчин бүрэн бүрдсэн. Иймд Санхүүгийн зохицуулах хорооноос даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэхээр “Даатгагчийн баталгаа” уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан юм. Уулзалт, хэлэлцүүлэгт Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Монголын даатгалын холбоо, “Үндэсний давхар даатгал” ХК болон даатгалын компаниудын төлөөлөл оролцож, даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар хэлэлцэж, санал солилцов.


Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагаа нь даатгалын салбарт нэвтэрч буй санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ юм.

Уг бүтээгдэхүүн, үйлчилгээг амжилттай хэрэгжүүлэх, даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагаанд нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцох, хамтын удирдлагын бүтцийг бий болгох, хамтын эрсдэлийн санг бүрдүүлэх чиглэлээр даатгалын компаниуд хамтран ажиллаж, даатгагчийн гаргах баталгааны үйл ажиллагааны журам, баталгааны гэрээний төсөл зэргийг боловсруулсан бол “Үндэсний давхар даатгал” ХК нь даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд андеррайтингийн туслалцаа үзүүлэх, даатгагчийн баталгааны эрсдэлийн тодорхой хэсгийг өөрийн хөрөнгөөр хариуцах, олон улсын давхар даатгалд шилжүүлэх чиглэлээр ажиллаж, холбогдох бэлтгэл ажлуудыг бүрэн хангаад байна.

Манай улсын хувьд иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд аливаа тендерт оролцохдоо банкинд бэлэн мөнгө байршуулах, эсвэл зээл авах хэлбэрээр банкны баталгаа гаргуулдаг байсан нь банкны баталгаанд хөрөнгөө түгжих, санхүүгийн боломжгүй бол тендерт оролцох ч боломжгүй болох зэрэг хүндрэлийг учруулдаг байсан. Харин даатгалын компаниуд баталгаа гаргаж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд тендерийн үйл ажиллагаандаа даатгагчийн баталгааг ашиглах болсноор иргэд, аж ахуйн нэгжүүдэд учирч буй дээрх хүндрэлийг эдийн засгийн хувьд зардал багатайгаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар даатгалын компаниуд 50.0 орчим тэрбум төгрөгийн баталгааг гаргах боломжтой байна.

Даатгагчийн баталгаатай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг 7766-8001 тоот утсаар болон info@mia.mn цахим хаягаар авч болно.

ТОП 100 АЖ АХУЙН НЭГЖҮҮД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРАХ ГАРЦЫГ ХАМТДАА ХЭЛЭЛЦЭВ



Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил дэвшил, хүртээмжтэй өсөлтөд нэн тэргүүний ач холбогдолтой зүйл бол тогтвортой санхүүжилт болон ногоон бонд билээ. Ийм учраас Санхүүгийн

зохицуулах хороо ТОП-100 аж ахуйн нэгжүүдэд тогтвортой санхүүжилт, ногоон бондын ач холбогдол, тэдгээрийн зохицуулалтын орчны талаар мэдээлэл өгөх, аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт татах боломж, дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн талаар танилцуулж, санал солилцохоор “Санхүүжилт татах боломж–тогтвортой санхүү болон ногоон бонд” хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим /МҮХАУТ/, Олон улсын санхүүгийн корпораци /IFC/, Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо /ТОС холбоо/-той хамтран зохион байгуулсан хэлэлцүүлгийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан нээж үг хэлсэн бөгөөд тэрбээр “Санхүүгийн зохицуулах хороо МҮЦАЭХ-той хамтран өнгөрсөн онд үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын дунд IPO форумыг амжилттай зохион байгуулсан. Үүнээс хойш буюу өнөөдрийн байдлаар хөрөнгийн зах зээлд дотоодын 4 аж ахуйн нэгж IPO хийх замаар нийт 157.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлж, 1 компани 20.0 тэрбум төгрөгийн нээлттэй бонд гаргаж, биржийн бус зах зээл дээр 72 аж ахуйн нэгжээс 91 компанийн бонд гаргаж, нийт 996.0 орчим тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна.

Хэлэлцүүлэгт оролцогчдод хөрөнгийн зах зээлд үнэт цаас гаргахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг танилцуулж мөн тогтвортой санхүү буюу олон улс бүс нутаг болон Монгол Улсын жишээ, компанийн бондын ач холбогдол, зохицуулалтын орчин, ногоон бондын талаар мэдээлэл өгч, санал солилцлоо.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО КАНАДЫН ҮНЭТ ЦААСНЫ БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХААР САНАЛ СОЛИЛЦЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан УИХ-ын гишүүн, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга

Т.Энхтүвшин, УИХ-ын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны гишүүн Д.Батлут, Х.Ганхуяг нарын хамтаар энэ сарын 01–04-ний өдрүүдэд Канад улсад албан айлчлал хийлээ. Энэхүү айлчлал нь санхүүгийн салбар тэр дундаа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, хоёр орны зохицуулагч болон дэд бүтцийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, тус улсын хөрөнгө оруулагчдыг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд оролцох идэвх сонирхлыг нэмэгдүүлэх цаашлаад улс орны эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр, дэмжлэг болгох зорилготой. Иймээс Канадын Үнэт цаасны зохицуулагчдын нэгдсэн байгууллага, Кебек болон Онтарио мужийн Санхүүгийн зохицуулагч байгууллагуудын үйл ажиллагаатай танилцахын зэрэгцээ хамтран ажиллах чиглэлээр холбогдох удирдлагуудтай нь албан уулзалт хийсэн юм. Тодруулбал, тус улсын Үнэт цаасны зохицуулагчдын нэгдсэн байгууллагын дарга Лаура Беллони, бодлогын менежер Светлана Фоулер, Кебекийн Санхүүгийн зохицуулагч байгууллагын дэд ерөнхийлөгч Ким Лачапелле, мониторинг, эрсдэл, үнэлгээний газрын дарга Виржиние Чане-Тенг, ахлах шинжээч Шэрон Келли болон холбогдох албаны бусад удирдлагуудтай албан уулзалт хийлээ.

Уулзалтуудаар хоёр орны хөрөнгийн зах зээлийг уялдуулан хөгжүүлэх, Санхүүгийн зохицуулах хороог мужуудын санхүүгийн зах зээлийн салбарт зохицуулагч байгууллагуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх талаар санал солилцсон юм. Мөн Монгол, Канадын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын давхар бүртгэл, шууд бүртгэлийн хялбаршуулсан горимыг нэвтрүүлэх, хоёр орны санхүүгийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын Санхүүгийн хориг арга хэмжээг авах байгууллага /FATF/-ын комплайнсын шаардлагуудыг хангуулахад хамтарч ажиллах талаар хэлэлцэв. УИХ-ын гишүүдээс энэ үеэр Монгол Улсад Канадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх талаарх саналуудыг дэвшүүлж цаашид хэрхэн хамтран ажиллах талаар зөвлөлдлөө.



БАЙР СУУРЬ

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ХӨГЖИЛД ГИШҮҮН БҮР МЭДЛЭГ, УР ЧАДВАР, ТУРШЛАГАА ОРОЛЦУУЛЖ, ХЯНАЛТАА ТАВИХ НЬ ЧУХАЛ

Хадгаламж, зээлийн хоршооны салбарт (цаашид “ХЗХ” гэх) Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй ТА 9654–МОН: “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн үндэсний зөвлөх Т.Оюунчимэгтэй төслийн талаар болон хадгаламж, зээлийн хоршооны салбарын хөгжлийн талаар ярилцлаа.



Та бичил санхүү нь ХЗХ-ны давуу тал онцлогт үндэслэсэн гэж хэллээ?

Тэгэхээр бичил санхүүгийн “багш” болсон ХЗХ нь иргэдийн дундын өмчлөл, удирдлага, хяналттай санхүүгийн байгууллага болохын хувьд орон нутагт санхүүгийн хүртээмжийг хөгжүүлэх, “нутгийн банк” болон ажиллаж байгаа нь давуу тал болдог. Энэ давуу талыг олон улсын байгууллагууд иргэдэд санхүүгийн үйлчилгээг нэмэгдүүлэх, нийгэмд иргэдийн оролцоо, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, орлого амьжиргааг дээшлүүлэх гүүр болгон ашигладаг.

ХЗХ нь иргэдэд санхүүгийн боловсролыг олгодог, орлогын ухаалаг зарцуулалт, хуримтлалд сургадаг, ирээдүйд гарах зардлаа зээлээр бус өөрийн хуримтлалаар санхүүжүүлэхийг сургаж, гишүүдийнхээ хэрэгцээнд нийцсэн онцлог бүхий бүтээгдэхүүнүүдийг гаргаж гишүүдээ ч хадгаламжтай болгон хоршоогоо ч өсгөж томруулдаг.

Түүнчлэн хөдөөд иргэдэд шаардлагатай нийгэм, соёлын хэрэгцээг өгдөг тул хүн амыг төв рүү чиглэх хөдөлгөөнийг сааруулахад тусалдаг гэдэг нь Канад улсад тогтоогдсон байдаг. Дашрамд хэлэхэд Канад улсад иргэдэд банкнаас үзүүлдэг санхүүгийн бүх үйлчилгээг ХЗХ-д нь үзүүлдэг, хөдөөгийн хот тосгодод ХЗХ нь дэлхийд алдартай том банкуудын салбараас эргэлдэж буй хөрөнгийн хэмжээ, үйлчлүүлэгчдийн тоо, оффис, барилга байшингаараа ч хамаагүй том байдаг.

Иргэдийн сэтгэлгээ ядуу бол амьжиргаа нь ч ядуу байдаг гэдгийг сүүлийн үед судлаачид тогтоогоод байна. Тэгэхээр ХЗХ-ны иргэдэд олгодог санхүүгийн боловсрол нь сэтгэлгээ, мөнгө санхүүд хандах хандлагыг нь өөрчлөхөд чиглэдэг, өөрөөр хэлбэл бага гэлтгүй орлогоосоо хуримтлал үүсгэх, ухаалаг зарцуулалт хийх, хэмнэх, санхүүгийн хариуцлагатай байхад сургадаг. Ингэснээр ирээдүйн зардлаа зээлээр хангах бус эртнээс хуримтлуулж хүүгийн зардлаа хэмнэдэг, хуримтлуулж сурсан хүн зээл авсан ч хариуцлагатай байдаг зэрэг олон давуу талыг бий болгодог.

ХЗХ нь иргэдийн санхүүгийн мэдлэг боловсрол дээшилж, санхүүгийн сахилга бат, зөв хандлагад шилжихэд, мөн санхүүгийн хүртээмж нэмэгдэхэд чухал нөлөөтэй болох нь харагдаж байна. ХЗХ-ны үүссэн түүх, дэлхий нийтэд тархсан байдлын талаар сонирхуулбал аль улсын ХЗХ-д дэлхийд хөгжлөөрөө тэргүүлж байгаа вэ?

Анх 1850–аад онд Герман улсад ядуу тариачид, үйлдвэрийн ажилчид өрийн дарамтаас гарах зорилгоор өөрсдийн хуримтлалыг бага багаар бүрдүүлэн эхэлсэн түүхтэй. Улмаар 1860–1900 онд баруун Европын Англи, Итали, Бельги, Нидерланд зэрэг орнуудад дэлгэрч 1900 оноос Канадаас эхлэн хойд Америкт, 1909 оноос Африк, 1912 онд Азид хамгийн анх Энэтхэгт хөгжиж эхэлсэн байдаг. Өнөөг хүртэлх хугацаанд олон улсад баримталдаг ХЗХ-ны зарчмууд, үнэт зүйлээ улам чамбайруулан бүх улс оронд

мөрдөж ирсэн учраас банк зэрэг бусад санхүүгийн байгууллагатай өрсөлдөх чадвартайгаар оршин тогтнож ирсэн. Дэлхийн 6 тивийн 120 гаруй улсад 90 мянга орчим ХЗХ-д нийт 3.5 их наяд ам.долларын хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна. Нийт хөрөнгийн хэмжээ, зах зээлд нэвтрэлтийн хувийг авч үзвэл АНУ, Канад, Герман, Ирланд, Карибын орнуудын ХЗХ-д хөгжлөөрөө манлайлж байна гэж хэлж болно. Зах зээлийн нэвтрэлт нь АНУ-д 61 хувь, Канадад 43 хувь байдаг.

2007–2008 оны дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралын байдал үр нөлөөнд Олон улсын хөдөлмөрийн байгууллага шинжилгээ хийж “ХЗХ, Хоршоод нь компани болон бусад төрлийн ААН-ээс хямрал хамгийн бага, амжилттай даван туулсан” гэж дүгнэсэн тул 2012 оныг Нэгдсэн үндэстний байгууллагаас “Олон улсын хоршооллын жил” болгон зарлаж байсан. АНУ-д хийсэн судалгаагаар тус улсын ХЗХ-д хямралд бага өртсөн салбараар тогтоогдсон төдийгүй, ХЗХ-оос ЖДҮ-д олгох зээл 2 дахин өссөн, гишүүдийнх нь сэтгэл ханамж банкнаас 80 хувь илүү байсан байдаг.

Ер нь системийн шинжтэй үндэстэн дамнасан хямрал болоход орон нутгийн хэмжээнд өөрсдийн нөөцөөр үйлдвэрлэл үйлчилгээ явуулж, өөрсдөө бүтээгдэхүүн үйлчилгээг нь хэрэглэдэг загвар бүхий бизнесүүд хамгийн бага сөрөг нөлөөнд автдаг нь сүүлийн 30 жилд тохиосон 2–3 хямралаар тогтоогдсон байдаг. ХЗХ нь тухайн иргэдийн бүлэг, хот тосгон, суурингийн хэмжээндээ үйл ажиллагаа явуулдаг, гэхдээ бүтээгдэхүүн үйлчилгээний баялаг төрөлтэй байдгаараа хямралд бага өртдөг, байнга өсөлттэй байдаг.

ХЗХ-ны бусад санхүүгийн байгууллагаас ялгагдах онцлог юу вэ? ХЗХ эрсдэлээ зөв удирдаад, зорилгодоо хүрч, өсөж дэвшихэд ямар хүчин зүйл хамгийн ихээр нөлөөлөх вэ?

Гишүүд нь ХЗХ-ныхоо эзэд нь байдаг. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 200 шахам ХЗХ-ны 72 мянган гишүүд бүгд ХЗХ-ныхоо эзэд нь гэсэн үг. Гишүүд бүгд хувь хөрөнгөө оруулна, хамтарч удирдана, шийдвэрээ гаргана, хянаана. Үйл ажиллагааг нь хялбаршуулаад томьёолбол гишүүд нь хөрөнгөө өөрсдөө тал талаасаа оруулаад, эргүүлээд өөрсдөө зээл авч байгаа. Тэгэхээр гишүүд нь байнгын мэдээлэл авч, идэвхтэй, хариуцлагатай байх, улмаар ХЗХ-г удирдах, дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр өөрсдийгөө төлөөлүүлэн дотроосоо сонгож байгаа тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөлийнхөө үйл ажиллагаанд хяналт тавьж, дүгнэж цэгнэдэг байх нь чухал.

ХЗХ-ны удирдлага хяналт нь 50 гишүүний 50 тархи, 100 нүд, 100 чих юм гэж ХЗХ-г анхны санаачлагчдын хэлсэн гоё үг байдаг.

Энэ үг нь ХЗХ-ны давуу тал онцлогийг маш товч тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, ХЗХ-г удирдахад гишүүн бүр мэдлэг, ур чадвар, туршлагаа оролцуул, эргээд бүгд хяналтаа тавихад дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр эрсдэл тохиолдох магадлалыг бараг үгүй болгоно. Товчхондоо эрсдэлийг удирдах, өсч дэвшихэд гишүүдийн оролцоо маш чухал.

Дараагийн асуудал нь гишүүдийн сургалт боловсрол. Хадгаламжаас хэвийн зээлийн хамаарал 74 хувь байдаг. Энэ ч утгаараа ХЗХ нь санхүүгийн боловсрол олгодог тул чанаргүй зээлийн хувь хэмжээ нь банк, банк бус санхүүгийн байгууллагаас эрс бага байдаг давуу талтай.

Манай улсын хувьд ХЗХ-ны салбар хөгжсөнөөр нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөг нь Та юу гэж хардаг вэ?

ХЗХ-ны давуу тал, онцлогоор нэг бүрчлэн тодорхойлбол маш их эерэг нөлөө харагдана. Ганц хоёр зүйлийг жишээ болгон онцлохыг хүсэж байна.

Юуны түрүүнд, санхүүгийн салбарын хараат бус бие даасан байдалд том хувь нэмэр оруулдаг. Манай ХЗХ-дын гишүүд нь Монгол Улсын иргэд, ААН байдаг. Тэгэхээр 100 хувь үндэсний мэдлийн санхүүгийн салбар бөгөөд аль нэг улс орон, иргэн, ААН-ээс хараат бусаар, бие даан шийдвэрээ гаргаж, үйл ажиллагаагаа явуулна гэсэн үг. Хамгийн сүүлд авсан нэг сонирхолтой мэдээллийг хуваалцахад дайн болж байгаа Украинд ХЗХ-дынх нь үйл ажиллагаа зогсоогүй, эдийн засгийн хоригт орсон Орос улсад банкуудын үйл ажиллагаа маш ихээр хязгаарлагдаж байхад 900 гаруй ХЗХ нь хагас сая шахам гишүүддээ үйлчилгээгээ үзүүлсээр байна гэсэн.

Дараагийн дугаарт, орон нутгийн хөгжил. Банкууд бүх сум сууринд хүрч чадаж байгаа нь сайшаалтай. Гэвч банкны зээлийн хүү гэдэг тухайн аймаг, сумаас гарч байгаа мөнгөн урсгал. Тэгэхээр хөдөө орон нутгийг хөгжүүлэхэд нэн тэргүүнд гадагшлах урсгалыг нь бууруулах, улмаар орох мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх нь чухал. Түүвэр судалгаа хийж үзэхэд дунджаар 2500–3500 хүн амтай сумдад 2–3 банкны салбар ажиллаж, тэдгээрийн олгосон нийт зээл нь 3.5–4.0 тэрбум төгрөг гарч байсан. Иргэдэд олгож буй зээлийн жилийн хүү, шимтгэл одоо дунджаар 20–22 хувь байгааг тооцож үзэхэд тухайн сумаас жилдээ 700.0–800.0 сая төгрөг хүүнд гараад явчаж байна. 1 өрхөд дунджаар 1.0 сая төгрөг гэсэн үг. Иймд ХЗХ энэ орлогыг сумандаа үлдээх боломжтой.

Гуравдугаарт, иргэдэд санхүүгийн боловсрол олгох, хуримтлалд сургах. 2022 оны эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны гаргасан ХЗХ-ны тайлан нэгтгэлээр 1 хадгаламж эзэмшигчид ногдох хадгаламжийн дундаж дүн 4.8 сая төгрөг


байна. Томоохон хадгаламжтай хүмүүс банкыг сонгодог, харин ХЗХ-ны гишүүдийн хадгаламж нь санхүүгийн боловсрол олгосны, хуримтлалд сургасны, хэрэгцээ сонирхолд нь нийцсэн зорилтот хадгаламжийн бүтээгдэхүүнүүд гаргасны үр дүн байдаг. Улс орны ДНБ нь иргэдийн санхүүгийн боловсролын индексээс шууд хамаардаг, Монгол Улсын иргэдийн санхүүгийн боловсролын индекс 24 хувь, харин хөгжингүй орнуудынх 60–80 хувь байдаг. Тэгэхээр иргэдэд санхүүгийн боловсрол олгодог цор ганц санхүүгийн байгууллага болох ХЗХ-г хөгжүүлэх нь улс орны эдийн засгийн хөгжилд том хувь нэмэртэй нь ойлгомжтой. Хадгаламжаас улсын зээлийн хамаарал 31 хувь байдаг. Улсын гадаад өрийн дарамт нэмэгдсээр ирсэн цаг үед иргэдийн санхүүгийн боловсрол, хуримтлалд сургах асуудлыг чухалчлан авч үзэхээс өөр аргагүй юм.

Нэг бодит жишээ дурдъя. Алслагдсан суманд 29 гишүүнтэй үүсгэн байгуулагдсан ХЗХ 5 жил хүрэхгүй хугацаанд 600 гишүүнтэй, 2.0 орчим тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болж өргөжиж, 4–5 хүнийг тогтмол цалинжуулж байна. Улмаар 300.0 орчим сая төгрөгийн зээлийн хүүг сумандаа үлдээж, 140.0 орчим сая төгрөгийн хүүгээр гишүүдийнхээ орлогыг нэмэгдүүлсэн байна. Энэ боломж бүх сумдад байгаа.

Төслийн талаар мэдээлэл өгөхгүй юу? Төслийн ажлын явц ямар шатандаа явж байгаа вэ?

Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд ХЗХ-ны эрх зүйн орчин, хяналт зохицуулалт, эрсдэлийн удирдлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа. Төслийн хүрээнд иргэдийн хөрөнгийг эрсдэхээс сэргийлэх, ХЗХ-дын тогтвортой ажиллагаа, өсөлтийг хангах, эрсдэлээс хамгаалах зорилго бүхий ХЗХ-ны макро орчин гэж хэлж болох ХЗХ-дын хадгаламжийн даатгал, тогтворжилтын сан, төвлөрсөн санхүүгийн байгууллага зэрэг дэмжих бүтцүүдийг бий болгоход шаардагдах эрх зүйн орчныг тодорхойлж, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийг холбогдох үндэслэл, тооцоолол, судалгааны хамт Санхүүгийн зохицуулах хороотой хамтран боловсруулж, өргөн барихад бэлэн болгосон.

***Танд ажлын амжилт хүсье.
Цаг заваа гарган ярилцсанд баярлалаа.***



ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

“ДААТГАГЧИЙН БАТАЛГАА ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”-ЫН ТАНИЛЦУУЛГА

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 46 дугаар тогтоолоор “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ыг “Даатгалын багц дүрэм”-ийн 19 дүгээр хавсралт болгон нэмж баталлаа.

“Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-аар даатгагч Даатгалын тухай хуульд заасан даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагыг тогтоох, түүнд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах бөгөөд тус журам нь 3 бүлэг, 2 хавсралтаас бүрдэнэ. Даатгагч нь

даатгагчийн бусад үйл ажиллагаанд хамаарах Даатгалын тухай хуулийн 61.1-д заасан баталгааг гаргаж болох бөгөөд баталгаа гаргахад Иргэний хуулийн 234, 457 дугаар зүйлийг баримтална.

Даатгагч баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх эсэхийг компанийн эрх бүхий этгээд шийдвэрлэх ба баталгаа гаргах үйл ажиллагааг хариуцсан бие даасан нэгжтэй байхаар журамд тусгасан. Мөн баталгаа гаргах үйл ажиллагаанд тухайн даатгагчийн ТУЗ-өөс дараах харилцааг тусгаж, баталсан тусгайлсан журмыг дагаж мөрдөнө.



Түүнчлэн даатгагчийн гаргаж болох баталгааны нийт дүн нь даатгагчийн өөрийн хөрөнгийн дүнгээс эрсдэлд суурилсан хөрөнгө болон нийт зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хассан үлдэгдлийн 70 хувиас хэтрэхгүй байх бөгөөд даатгагч баталгаа гаргах бүрт дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

- Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа 110 ба түүнээс дээш хувь байх;
- Баталгааны нөхцөл, үнэ нэмэгдсэн, өөрчлөгдсөн эсэхээс үл хамааран баталгаа нь тухайн гэрээний нийт үнийн дүнгийн 20 хувиас хэтрэхгүй байх;
- Баталгааны гэрээ дуусгавар болох хүртэл баталгаа гаргасан дүнтэй тэнцүү хэмжээний мөнгөн хөрөнгийг төлбөр түргэн гүйцэтгэх боломжтой байдлаар байршуулсан байх.

Мөн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх даатгагч нар нь хамтран тухайн даатгагч нарын гишүүнчлэлээс бүрдсэн хамтын удирдлагын бүтцийг бий болгож ажиллах шаардлагыг тусгасан. Тус бүтэц нь баталгааны гэрээний нийтлэг загвар гаргах, мэдээллийн нэгдсэн сан болон хамтын эрсдэлийн санг байгуулах, удирдах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх юм. Дээрх сангуудыг байгуулснаар харилцагчаа таних, эрсдэлийн үнэлгээ хийх, улмаар салбарын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой болно.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

САНХҮҮЖИЛТ ТАТАХ НОГООН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 онд Дэлхийн банкны зөвлөхөөр ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсад хөгжүүлэх судалгааг хийлгүүлсэн. Тус судалгаа нь Монгол Улс дахь өнөөгийн нөхцөл байдлыг дүгнэж, олон улс дахь сайн туршлагад үндэслэн хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, банк бус санхүүгийн байгууллагуудын салбар болон хадгаламж, зээлийн хоршооны салбарт хөгжүүлэх ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээний саналыг боловсруулсан.

Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэхэд төр болон хувийн хэвшлийн оролцоо хамтдаа чухал байдаг.



Ногоон санхүүгийн зах зээл нь ногоон төслийг дэмжихийн тулд зохицуулалтын тохиромжтой хөшүүргийг ашиглах, харин хувийн хэвшлийн оролцогч талууд санхүүжилтийн боломж, шаардлагын талаар мэдээлэх зоригтой байх хэрэгтэй. Засгийн газрын бодлого бага нөлөө бүхий төсөл болон ногоон дэд бүтцийг дэмжиж, санхүүжүүлэх хэрэгтэй. Зохицуулалтын хөшүүргийн хувьд нийгмийн өртөг, үр өгөөжийг хангах олон төрлийн татвар

болон татаасны бодлого хэрэгждэг. Тухайлбал шинэ, эрсдэлтэй технологид хөрөнгө оруулалт хийхэд татварын зээлийн бодлого, эсрэгээрээ тамхины татвар, нүүрстөрөгчийн үнэ тогтооход тариф тогтоодог байна.

Ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд ногоон бонд, ногоон зээлийн санхүүжилтийн орчныг бүрдүүлэхээс гадна эрсдэл бууруулах, хөрөнгө оруулагчдыг хамгаалах бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлснээр систем бүрэн болдог байна.

Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэхэд гуравдагч чухал хүчин зүйл нь байгаль орчны талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллийг олон нийтэд түгээх юм. Манай улсын хувьд ногоон хөрөнгө оруулалт, ногоон зээл, ногоон даатгалын хувьд хууль, эрх зүйн орчин үүсээд байгаа хэдий ч зах зээлд эзлэх хувь бага байгаа нь олон нийтийн мэдлэг мэдээлэл дутмаг байгаагийн улмаас эрэлт бага байна.

Үргэлжлэл бий...

ФИНТЕК БА РЕГТЕК

ИНШУРТЕК БА ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэнд иншуртек болон түүний өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаар мэдээлэл хүргэхээр бэлтгэлээ. Байгалийн гамшигт үзэгдэл болох гал түймэр, газар хөдлөлт, үер, хар салхи, гэнэтийн осол зэрэг тохиолдох хугацааг нь урьдчилан таамаглах боломжгүй, гэнэтийн шинжтэй эрсдэлүүд хувь хүн болон байгууллагуудад тохиолдож байдаг. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр цаг агаарын өөрчлөлт, дулаарлын улмаас байгалийн гамшигийн давтамж, эрсдэл тохиолдох магадлал улам бүр нэмэгдсээр байна. Энэхүү нөхцөл байдлыг дагаад дэлхий нийтээр даатгалын үнэ цэн, ач холбогдлыг ойлгож, тэр хирээр тухайн салбарын хөгжлийг хурдасгаж байгаа юм. Даатгалын салбарт ашиглаж байгаа технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг олон улсад “Иншуртек” /insurtech/ хэмээн томъёолж байгаа бөгөөд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологийн тусламжтайгаар даатгалын үйлчилгээг илүү хялбар, хүртээмжтэй болгож буй инновацад суурилсан цоо шинэ төрлийн үйлчилгээ юм.

Хиймэл оюун ухаан, блокчейн, үүлэн технологи, их өгөгдөл болон бусад хөгжингүй технологийн тусламжтайгаар тасралтгүй шинэчлэлт хийсний үр дүнд даатгалын салбар нь бүхэлдээ өөрчлөгдөж байна. Иншуртек ашиглан үйл ажиллагаагаа явуулж байгаа даатгагчдыг уламжлалт хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын компаниудтай харьцуулахад үр ашгийн хувьд үзүүлэлтүүд өндөр харагдаж байна.

Монгол Улсын хувьд ч технологид суурилсан даатгалын шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа бөгөөд хэд хэдэн даатгалын компаниуд үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг ашиглан үйлчлүүлэгчдэдээ түргэн шуурхай үйлчлэх, үйл ажиллагааныхаа зардлыг бууруулах, илүү нарийвчилсан эрсдэлийн үнэлгээ хийх зэрэг давуу талуудыг бий болгосоор байгаа билээ.

ДЭЛХИЙ НИЙТЭЭР ИНШУРТЕКИЙН ДАРААХ ТӨРЛҮҮДИЙГ ТҮЛХҮҮ ХӨГЖҮҮЛЖ БАЙНА:

Өнөөгийн байдлаар даатгалын компаниуд маркетинг, борлуулалт, бүтээгдэхүүний төрөл, андеррайтинг, нэхэмжлэлийн боловсруулалт зэрэг даатгалын үйлчилгээний бүх үе шатанд иншуртек ашиглаж байна.

1. Хиймэл оюун ухаан (AI) ба машин сургалт (ML)

Хиймэл оюун ухаан нь яриа таних, дүрсний дүн шинжилгээ хийх, нарийн төвөгтэй шийдвэр гаргах зэрэг хүний оюун ухааныг шаарддаг

уламжлалт ажлуудыг компьютер, алгоритм ашиглан гүйцэтгэдэг. Харин машин сургалт нь туршлага суралцах, урьдчилан таамаглах, нарийвчлалыг сайжруулах боломжийг олгодог. Өнөөгийн байдлаар иншуртек компаниуд үйлчилгээгээ сайжруулах, үйл ажиллагааны зардлыг бууруулж, үр ашгийг бий болгох зорилгоор хиймэл оюун ухаан, машин сургалтыг ашигладаг.

2. Зүйлсийн интернэт (IoT)

Зүйлсийн интернэт нь хөргөгч, машин, ухаалаг гар утас зэрэг өдөр тутмын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, ухаалаг үйлдвэр зэрэг бизнесийн үйл ажиллагаанд интернэт холболтыг ашиглах явдал юм. Энэ төрлийн технологи нь даатгагчдад мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үйлчлүүлэгчидтэй шинэ арга, хэлбэрээр харилцахад тусалдаг.

3. Робот техник, дрон болон бусад технологи

Хиймэл оюун ухаан болон зүйлсийн интернэтийг робот, дрон, өөрөө явах тээврийн хэрэгсэл зэрэг шинэ технологийг даатгалын салбарт нэвтрүүлэхэд ашиглаж байна. Эдгээр нь даатгагчид эрсдэлийг хэрхэн үнэлэх, нэхэмжлэлийг шийдвэрлэх, андеррайтерийн бодлогыг шинэчлэх боломжийг олгож байна.

4. Блокчейн

Блокчейн бол аюулгүй бүртгэл хөтлөлтийн нэг төрөл юм. Нууцлал, аюулгүй байдлыг сайжруулахын тулд олон даатгалын компаниуд болон пүүсүүд блокчейн технологийг дараах зорилгоор ашиглаж байна.

- Залилангаас урьдчилан сэргийлж, аюултай эсвэл хууль бус үйлдлийг илрүүлэх.
- Мэдээлэл дамжуулах, хадгалах ажлыг оновчтой болгох.
- Байгууллагын болон хувь хүний нууцлалтай холбоотой мэдээллүүд болох санхүүгийн гүйлгээ болон эмнэлгийн бүртгэлийн мэдээллийг хадгалах.

Эдгээр дижитал трендүүд нь даатгалын компаниудыг уламжлалт хэв маягаасаа давсан, илүү өргөн цар хүрээг хамарсан бизнесийн үйл ажиллагаа явуулах боломжийг олгож байна. Зөвхөн түүхэн өгөгдөл ашиглан үнийн тооцоолол, эрсдэлийн үнэлгээг хийдэг байсан бол дижитал технологи нь хэрэглэгч тус бүрээр, бодит цагийн горимоор эрсдэлийг шууд буюу автоматаар үнэлэх боломжийг олгохоос гадна


хэрэглэгчдэд гарч болох эрсдэлээс зайлсхийхэд дэмжлэг үзүүлж байгаа юм.

ИНШУРТЕКИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ, БАЙДАЛ

Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын сүлжээ байгууллага болох KPMG-ээс гаргадаг “Pulse of Fintech” финтекийн салбарын тойм 2023 оны 1 дүгээр сард нийтлэгдсэн бөгөөд үүнд иншуртекийн талаар холбогдох тоон үзүүлэлтүүдийг дараах байдлаар тусгажээ.

2022 онд Иншуртекийн салбарт хийсэн хөрөнгө оруулалт сүүлийн 7 жилийн түвшинтэй харьцуулахад 7.1 тэрбум ам.доллар буюу хамгийн бага үзүүлэлтэд хүрсэн нь сүүлийн жилүүдэд томоохон иншуртек компаниудын гаргасан хувьцааны үнэ унасантай холбоотой гэж дүгнэжээ.

Зураг. Дэлхийн иншуртекийн салбарын 2022 оны хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Өмнөх жилүүдийг ажиглахад зах зээлийн үнэлгээ тогтворжих тусам хөрөнгө оруулагчид идэвхижиж эхэлж байгаа нь ажиглагдсан бөгөөд 2022 оны макро эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас иншуртекийн хөрөнгө оруулалтын хувьд харьцангуй нам гүм жил байсан ба хөрөнгө оруулагчид эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдлыг хүлээж түр хугацаанд завсарласан. 2022 онд иншуртекийн салбарын хөрөнгө оруулагчид ашигт ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлж, компаниудын өсөлт болон үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэхэд бага анхаарлаа хандуулсан. Ийнхүү иншуртекийн салбарын хөрөнгө оруулалт буурснаар зарим гарааны бизнес эрхлэгчид өөрсдийн компанийн үнэлгээг бодитой тогтооход хүндрэл үүссэн байна.

2022 онд иншуртек компаниуд бүтээгдэхүүнийхээ төрлүүдийг нэмэгдүүлэх замаар үйл ажиллагаагаа өргөжүүлж, хэрэглэгчийн мэдлэг, туршлагыг нь сайжруулахад туслах зорилгоор уламжлалт даатгалын салбарын тоглогчдод чиглэсэн SaaS шийдлүүдийг санал болгож, гарааны бизнесүүдэд илүү их анхаарал хандуулж ажилласан байна.

Гэвч 2022 оны сүүлийн хагас жилд иншуртекийн салбарт хэд хэдэн эерэг үзүүлэлтүүд гарсан бөгөөд Америк тив болон Европ, Ойрх дорнод, Африкийн бүс нутаг, Ази, Номхон далайн бүс нутагт хэд хэдэн томоохон дүнтэй хэлэлцээрүүд хийгдсэн байна. Тэр дундаа АНУ-д төвтэй Metromile компанийг Lemonade компани 500.0 сая ам.доллараар худалдан авсан мөн Германд төвтэй Wefox компани 400.0 сая долларын венчур капиталын хөрөнгө оруулалт татсан, АНУ-ын Pie Insurance 315.0 сая ам.долларын венчур капиталын хөрөнгө оруулалт татсан, Сингапурт төвтэй Bolttech 300.0 сая ам.долларын капиталын хөрөнгө оруулалт татсан зэрэг үзүүлэлтүүд нь тус оны иншуртекийн салбарын онцлох, томоохон үйл явдлууд байсан.

2023 ОНЫ ИНШУРТЕКИЙН САЛБАРЫН ЧИГ, ХАНДЛАГА

- Хөрөнгө оруулагчид ашиг, орлого олох тодорхой төрлийн иншуртек;
- Даатгалын компаниуд өөрсдийн бизнест стратегийн ач холбогдолтой байж болох иншуртекийг эрэлхийлэх;
- Идэвхжүүлэлт болон SaaS шийдлүүд дээр төвлөрсөн иншуртек;
- Хөрөнгө оруулагчид эдийн засгийн хүнд нөхцөлд амжилттай хөгжиж ирсэн, зах зээлийн хүнд, хэцүү нөхцөл байдлыг даван туулж чадах иншуртекийн хувилбаруудад анхаарлаа хандуулах;
- Ази, Номхон далайн бүс нутагт стартапуудын тоо өсөж, технологийг цар хүрээгээ тэлэх, хөгжүүлэх хэрэгсэл болгон ашиглах зэрэгт голлон анхаарч байна.

СУДЛААЧИЙН ИНДЭР

СУПТЕКД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТ БА ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ /ХУРААНГУЙЛСАН/

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаанд Санхүүгийн зохицуулах хороонд эрсдэлд суурилсан хяналт шалгалтад технологийг нэвтрүүлэх буюу суптекийн тогтолцоонд шилжүүлэхэд стратегийг боловсруулах, анхаарах асуудлуудыг судлахыг зорьсон.

УДИРТГАЛ

Санхүүгийн зах зээлийн үндсэн үүрэг нь мөнгөний илүүдэлтэй хэсгээс эрэлттэй хэсэгт зуучлалын үүргийг гүйцэтгэж эдийн засгийн үйл ажиллагааг хурдасгах, хөрөнгийн тэгш хуваарилалтыг хийдэг. Санхүүгийн зах зээл дээрх мөнгө хэн нэгнээс нөгөөд шилжих үйл явц нь итгэлцэл дээр тогтодог ба санхүүгийн хэрэглэгчдийн зах зээлд итгэх итгэл нь уг салбарын тулгуур байдаг. Иймд санхүүгийн зохицуулагч зах зээлийн гажуудал /мэдээллийн тэгш бус байдал, зах зээлд ноёрхох, системийн эрсдэл/ үүсэхээс сэргийлэх шаардлага үүсдэг тул дараах зорилгыг хангахаар хяналт, зохицуулалтыг хийдэг:

- Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах;
- Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах;
- Санхүүгийн зах зээлийн шударга байдлын хангах /integrity/;
- Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

Уламжлалт санхүүгийн зохицуулалтын арга нь эрсдэлийг төдийлөн сайн илрүүлж чаддаггүй нь 1929 оны Их хямрал, 1997 оны Азийн валютын хямрал, 2009 оны Санхүүгийн хямрал, 2013 оны Европын бондын хямрал зэргийг урьдчилан таамаглаагүйн улмаас хямралд өртсөн байдлаар батлагдана.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт Н.Нарантуяа
narantuya@frc.mn

Түүнчлэн уламжлалт санхүүгийн тогтолцоонд технологийн дэвшлийг ашиглан хэрэглэгчдэд илүү таатай үйлчилгээг санал болгосон технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ /финтек/ дэлгэрсэн нь санхүүгийн зохицуулалтын өнөөгийн тогтолцооноос, бодит цагийн горимоор тоон мэдээллийг цуглуулан эрсдэлийг үнэлэх, эрт олж илрүүлэх технологид суурилсан зохицуулалтын аргачлал шаардагдаж байна.

Энэхүү шаардлагыг бодит цагийн горимоор, бүтэцлэгдсэн болон бүтэцлэгдээгүй өгөгдөлд суурилан эрсдэлийг автоматаар үнэлэн хянан шалгагчид эрт илрүүлэх дохиоллыг мэдэгдсэнээр зах зээлд учрах сөрөг нөлөөлөөс урьдчилан сэргийлэх давуу талыг зохицуулалтын регтек болон суптек хандлага шийдэх болсон. Регтек нь санхүүгийн зохицуулагчийн хувьд үр өгөөжөө өгөхөөс гадна санхүүгийн байгууллагуудад комплайнсын өсөн нэмэгдэж буй зардлыг бууруулах, эрсдэлийн сайн удирдлагыг хэрэгжүүлэх, тэр дундаа үйл ажиллагааны эрсдэлийг мэдэгдэхүйц бууруулах, хууль эрхзүйн болон нэр хүндийн эрсдэлийн нэмэгдэж буй тохиолдлыг бууруулахаар технологийн шийдлийг комплайнсын үйл ажиллагаанд ашигласан. Регтекийн тогтолцоо нь анх “засаглал, эрсдэл, комплайнс”-ыг нэгэн зэрэг хангахад яригдах болсноор өнөөдөр хөгжлийн гурав дахь хувилбар хөгжөөд байгаа ба суптек үүссэнээр зохицуулалтын тогтолцоог бүрэн хангаж, 2014 онд их өгөгдөл гарснаар улам ч сайжруулав.

Түүнчлэн 2009 оны санхүүгийн хямралаас хойш дүрэмд суурилсан зохицуулалтаас зарчимд суурилсан зохицуулалт руу шилжиж, уян хатан тогтолцоонд шилжих болсон ба регтек нь үүнийг хангах болсон.

Регтек нь хэрэглэгчээ танин мэдэх гэсэн зарчим дээр өгөгдлөө мэд гэсэн утгыг нэмдэг. Учир нь бодит цагийн горимоор олон эх сурвалжаас программ хангамжийн тусламжтайгаар өгөгдөл цуглуулан ашиглах боломжийг олгодог.

Зохицуулалтын регтек технологийн гол зорилго нь микро түвшинд механик ажиллагаагаар хийгдэж буй эрсдэлийн тооцоолол, баримт бичгийн боловсруулалт, шинжилгээ зэрэг асар их хүний оролцоо шаардсан процессуудыг техник, автоматжуулалт ашиглан бүр мөсөн халах бол макро түвшинд инновацыг дэмжин түүнд итгэх итгэлийг бий болгосноор ирээдүйн санхүүгийн салбарын хүртээмжтэй, тогтвортой байдлыг хангаж, дэлхий нийтийн эдийн засгийн өсөлтийг дэмжих явдал юм. Регтек нь зохицуулалтын байгууллагуудад тайлан мэдээгээ тодорхой стандарт, ангиллын дагуу алдаагүй тайлагнах, хянан шалгагчдад бизнесийн өгөгдлийг байгууллагын системээс шууд татаж авч хянах, дотоод системд нь нэвтрэх замаар үйл ажиллагааны өгөгдлийг харах, мэдээллийн санд агуулагдаагүй бүтэцлэгдсэн бус мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийх зэрэг боломжуудыг тус тус олгоно.

Регтекийг өнөөгийн манай орны нөхцөл байдалд ашигласнаар байгууллагыг бодит цагийн горимоор хянах, эрсдэл үүссэний дараа засаж залруулдаг хоцрогдолтой байдлыг арилгах, нэг хянан шалгагчид ногдох ачааллыг бууруулах, үүлэн тооцооллыг ашиглан илүү өргөн хүрээний дата өгөгдөл дээр боловсронгуй дүн шинжилгээ хийх, хяналт шалгалтын цар хүрээг нэмэгдүүлэх зэрэг зардал, цаг хугацааг хэмнэсэн олон давуу талыг бий болгон зохицуулалтын асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой.

Банкны систем давамгайлсан санхүүгийн салбар хөгжиж буй улс орнуудын хувьд нарийн төвөгтэй дэд бүтэц бүхий санхүүгийн системтэй хөгжингүй улс орнуудтай харьцуулахад хяналтын технологийг илүү хурдан хугацаанд нутагшуулах боломжтой. Хяналтын технологийг нэвтрүүлэхэд цаашдын санхүүгийн зохицуулалтын чиг хандлага, урт хугацааны хөгжлийн бодлого, стратегийн үзэл баримтлалыг тодорхойлсон байх шаардлагатай.

Тэр дундаа уламжлалт санхүүгийн салбарт хиймэл оюун ухаан, блокчэйн технологи, финтект суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтэрч зах зээлд мэдээллийн шинэлэг хэрэглээ, шинэ тоглогчид болон бизнесийн загварууд бий болсон. Түүнчлэн 2007 оноос эхэлсэн дэлхийн санхүүгийн хямрал тус зах зээлд цогц шинэчлэлийг эхлүүлж хяналт шалгалтыг хэрхэн үр нөлөөтэй хийх талаарх асуудлууд хөндөгдөж эхэлсэн.

Хэрэглэгчдэд олдож буй асар их боломжийг дагаад санхүүгийн зохицуулагч байгууллагуудад нөхцөл байдалтай уялдсан бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах таатай орчныг бүрдүүлэх, үндэсний төлбөрийн системд учруулах эрсдэлийг үр нөлөөтэй хянах, бууруулах зэрэг асуудлууд тулгамдан гарч ирсэн.

Технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ нь ард иргэд болон зохицуулалтын байгууллагуудад дундын зуучлагчгүй үйл ажиллагаа эрхлэх, зайнаас харилцаа тогтоох, хэрэглэгчийн зардлыг бууруулах замаар үр ашиг, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх гээд олон давуу талыг олгодог. Гэвч нөгөө талаас энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь улс орнуудын зах зээлд харьцангуй шинэлэг зүйл бөгөөд зохицуулалтын орчин хангалтгүй, харилцагчдыг зайнаас таньж мэдэх нь гэмт хэрэгт өртөмтгий байдлыг нэмэгдүүлдэг, их хэмжээний хөрөнгийн урсгал эргэлддэг, хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй технологийн шийдлээс хэт хамааралтай байх нь технологийн доголдлоос үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг, дижитал өгөгдлийн кибер аюулгүй байдал, сүлжээний аюулгүй байдал алдагдах гээд олон ноцтой асуудлуудыг бий болгодог.

Олон улсын санхүүгийн зохицуулагч байгууллагуудын хувьд тухайн зах зээлийн цаашдын хөгжлийг тасралтгүй хангахаас гадна оновчтой менежментийн тусламжтайгаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх, салбарын тогтвортой байдлыг хадгалах, цаг үетэй уялдуулан тогтмол хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах, хяналт шалгалтын арга хэлбэрийг шинэчилж байх зэрэг томоохон сорилтуудтай тулгараад байна. Дэлхий нийтийн хяналт, зохицуулалтын шинэ эрин үе нь ганц технологид суурилах бус, олон технологийн хослолуудад тулгуурлаж байгаа бөгөөд манай улсын хувьд уг чиг хандлагатай хөл нийлүүлэн алхах шаардлагатай.

Иймээс санхүүгийн зохицуулагч байгууллагуудын өмнө санхүүгийн технологийг хянах, эрсдэлийг урьдчилан таамаглахын тулд бодит цагийн горимд суурилсан өгөгдлийг ашиглан үнэлгээ хийх, эрсдэлийг олон хүчин зүйлээс хамааруулан шинжлэх зэрэг шаардлагууд үүссэн. Дээрх асуудлуудыг шийдвэрлэх өнөөгийн шийдэл нь суптек буюу технологид суурилсан зайны хяналт юм. Иймд энэхүү судалгаанд регтек, суптек болон их өгөгдлийн талаар судалж, хяналт, зохицуулалтын арга хэрэгсэлд суптекийг хэрхэн нэвтрүүлэх талаар судаллаа.

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧИД ТАВИХ ШАЛГУУР, НӨХЦӨЛ

Биржийн бус зах зээл нь албан ёсны бус боловч, зохион байгуулалт сайтай, нэг болон хэд хэдэн дилерүүдийн төвлөрсөн арилжааны сүлжээ гэдгээрээ хөрөнгийн биржээс ялгаатай. Дилер нь үнэт цаасны үнэ тогтоох, худалдах, худалдан авах замаар зах зээлд оролцогчийн үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь бусад үйлчлүүлэгч, дилерүүдэд ижил үнэ санал болгоно гэсэн үг биш.

Дилерүүд нь биржийн бус зах зээлээс хэдийд ч гарч болдог боловч энэ нь хөрвөх чадвар алдагдах, зах зээлд оролцогчдын худалдах, худалдан авах чадварыг алдагдуулах эрсдэл дагуулдаг. Хөрөнгийн бирж дээр үнэт цаасны үнэ ханш ил тод байдаг тул хөрвөх чадвар сайтай байдаг. Харин биржийн бус зах зээл дээр ил тод байдал бага, дүрэм журам арай сул зохицуулалттай байдаг. 2007 онд АНУ-ын ипотекийн зах зээлд гарсан хямралын улмаас үүссэн бүх үнэт цаас болон санхүүгийн үүсмэл хэрэгсэл биржийн бус зах зээл дээр арилжаалагдсан.

Дилерүүд нь үнэ тогтоох, үнийн санал асуух, тохиролцохдоо утсаар, мэйлээр, мессежээр харилцдаг. Улмаар үнийн саналыг цахим мэдээллийн самбар дээр байршуулдаг боловч хүн бүр нэвтрэх боломжгүй байдаг.

ОРЧИН ҮЕИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ШИНЭ ХАНДЛАГА БУЮУ РЕГТЕК БОЛОН СУПТЕКИЙН ТУХАЙ

Шийдэл ба регтек

Регтек нь их өгөгдөлд суурилан бүтэцлэгдсэн ба бүтэцлэгдээгүй мэдээнд үнэлгээ хийдгээрээ зах зээлд оролцогчдын зан төлөвийг тодорхойлж эрсдэлийг урьдчилан таамаглах магадлалыг улам өсгөдөг. Регтек нь санхүүгийн зохицуулалтын 4 зорилгыг хангахад бодит цагийн горимоор их өгөгдөлд олон эх сурвалжаас мэдээ цуглуулан, түүнд нарийвчилсан үнэлгээг систем автоматаар хийж эрсдэлийг илрүүлдгээрээ цаг хэмнэсэн, үйл ажиллагааг багасгасан шийдэл болсон. Тухайлбал эрсдэлийг үнэлэх стресс тест, капиталын шаардлагыг тооцох, залиланг эрт илрүүлэх, сэжигтэй гүйлгээний дохиолол зэрэг нь платформд суурилах юм.

Регтекийн хөгжлийн 3 загвар байгаа бөгөөд анх 1990–2000 оны хооронд Регтек 1.0 загвар үүссэн ба технологийн хөгжилд төвлөрөн хөгжүүлсэн байдаг. 2010 онд Регтек 2.0 загвар гарсан нь регтек хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд суурилан хөгжүүлэх болсон. 2020 онд Регтек 3.0 загвар нь их өгөгдлөөс ухаалаг өгөгдөл рүү шилжих болсон.

Ерөнхийдөө биржийн бус зах зээлд үндсэн хоёр ангилал бий. Эхнийх нь үйлчлүүлэгчийн зах зээл буюу дилер болон хувь хүмүүс эсхүл хедж сан зэрэг мэргэжлийн хөрөнгө оруулагч хоорондын хоёр талт арилжааг хэлнэ. Дилерүүд ихэвчлэн үнэт цаас, санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон тэдгээрийг худалдаж авах, худалдахад бэлэн байгаа үнийг жагсаасан "дилерийн гүйлгээ" хэмээх их хэмжээний цахим мессежээр дамжуулан үйлчлүүлэгчидтэйгээ холбоо тогтоодог.

Харин хоёр дахь ангилал буюу дилер хоорондын зах зээл дээр дилерүүд бие биедээ үнийн санал тавин арилжаа хийдэг. Дилер, дилертэйгээ шууд холбогдох бөгөөд ингэснээр цаг алдалгүй хурдан шуурхай ажиллах боломжтой юм.

Биржийн бус зах зээлийн арилжаанд ихэвчлэн хамтын хөрөнгө оруулалтын сан, хедж сан зэрэг мэргэжлийн хөрөнгө оруулагчид оролцох хандлагатай байдаг. Гэсэн хэдий ч Колумбын их сургуулийн 2013 оны судалгаагаар нэгж хувьцааны үнэ 5.0 ам.доллараас бага Penny stocks буюу ЖДҮ эрхлэгчдийн хувьцааг жижиг хөрөнгө оруулагчид эзэмшдэг байна.

Биржийн бус зах зээл дээр томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас эхлээд жижиг хөрөнгө оруулагч зэрэг аль ч хөрөнгө оруулагчид бүртгэлтэй брокер дилерээр дамжуулан оролцож болно.

Зохицуулалтын орчинд регтек нь дараах хүрээг хамардаг:

- Арилжааны хяналт ба мониторинг
- Харилцагчийг таньж мэдэх, мөнгө угаахын эсрэг комплайнс
- Зохицуулалтын анализ /intelligence/
- Тайлагнал ба эрсдэлийн удирдлага

Регтек нь уламжлалт зохицуулалтын аргачлалтай харьцуулахад дараах давуу талуудтай:

- Комплайнсын өртгийг бууруулах;
- Комплайнсгүй байх үеийн эрсдэлийг бууруулах;
- Бодит цагийн хамгаалалт;
- Эх үүсвэрийн хэрэглээг дээд түвшинд ашиглах;
- Хянан шалгагчийн цагийг хэмнэх;
- Хяналтын явцыг сайжруулах.

Регтекийн санхүүгийн зохицуулагч байгууллагын хяналт шалгалт, зохицуулалтад ашиглагддаг хэлбэрийг суптек буюу хяналтын технологи юм.

Суптек буюу технологид суурилсан хяналт шалгалт

2009 оны санхүүгийн хямралаас хойш санхүүгийн зохицуулагч байгууллагууд нь эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо руу шилжсэн. Санхүүгийн зохицуулах хорооны 2021 онд баталсан “Хяналт шалгалтын бодлогын баримт бичиг”-т эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг зохицуулалттай этгээдийн тухайн цаг үед болон ирээдүйд бий болох эрсдэлийг тодорхойлж, үүн дээр шинжилгээ хийж үнэлгээ боловсруулан, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг цогц систем гэж тодорхойлсон байдаг. Мөн суптек нь санхүүгийн байгууллагын эрсдэл, комплайнсын хяналтыг сайжруулахаар зохицуулалт, тайлагналын процессыг дижиталчлах ба хяналт шалгалтын

тоон өгөгдлийн хязгаарлагдмал байдал болон гар ажиллагааны улмаас их цаг зарцуулдаг асуудлыг шийдвэрлэсэн.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг оновчтой хэрэгжүүлэхэд суптек буюу технологид суурилсан хяналт шалгалт дэмждэг ба өгөгдөл цуглуулах болон өгөгдөлд дүн шинжилгээ хийх гэсэн хоёр хэсгээс бүрддэг. Суптек нь сарын болон улирлын давтамжтай цуглуулдаг байсан өгөгдлийг хамгийн нарийвчилсан байдлаар, бодит цагийн горимоор мэдээллийн санд татан төвлөрүүлж, эрсдэлийн үнэлэх аргачлалыг ашиглах хүчин чадал сайтай технологиудтай тул эрсдэлд суурилсан үнэлгээг автоматжуулснаар хянан шалгагчийг эрсдэлийн эсрэг авах хариу арга хэмжээнд илүүтэй төвлөрөх боломжийг олгодог.

Суптек нь өнөөгийн хөгжилдөө хүрэх хүртэл дөрвөн үе шатыг дамжсан.

Зураг. Суптекийн хөгжлийн 4 үе



Эх сурвалж: BIS

1G технологийн үе: Өгөгдлийн удирдлагын ажлын урсгал нь гар ажиллагаа ихтэй ба дискриптив шинжилгээ хийгддэг. Өгөгдөл цуглуулахад тайлангууд нь цахим шуудангаар ирдэг ба файлын багтаамж хязгаарлагдмал, үйл ажиллагааны болон нууцлалын эрсдэл үүсдэг. Өгөгдлийг гараар нэгтгэж, цэгцэлдэг ба нэгдсэн өгөгдлийн сангийн оронд тус тусдаа мэдээллийн баазад хадгалагддаг. Өгөгдөл болон мэдээллийн сангийн дэд бүтцийн хязгаарлалт, дутмаг байдлын улмаас шинжилгээ, үнэлгээ нь дискриптив болдог.

2G өгөгдлийн архитектур: Өгөгдөл дэх цаасанд суурилсан болон гар ажиллагаа шаардсан ажлууд автоматжиж, дижиталчлагдсан. Вэбэд суурилсан портал болон автомат шалгах горимд шилжсэн.

3G их өгөгдлийн архитектур: Өгөгдлийн архитектур нь технологиор бүтээгдсэн тул өмнөхөөсөө илүү давтамжтай, их хэмжээний өгөгдлийг дэмждэг болсон. Өгөгдөл боловсруулах, нэгтгэх процесс бүхэлдээ автоматажсан. Өгөгдлийг үүлэн технологи ашиглан нэгдсэн санд хадгалдаг болсон бол тооцооллыг илүү дэвшилтэт статистик загвараар үнэлэх боломж бий болсон.

4G Хиймэл оюун ухааны шийдэл ба их өгөгдлийн архитектур: Их хэмжээний өгөгдөл, сайтар тооцоолох хүчин чадал нийлээд үнэлгээний үр дүнг хэрэгжихүйц, үнэ цэнтэй гаргах болсон.

ЗАГВАР, ТУРШЛАГА, ХАНДЛАГА

Олон улсын төлбөр тооцооны байгууллагаас судалсан “Суптекийн хөгжлийн үе шат” судалгаанд нийт 31 улсын 39 зохицуулагч байгууллага хамрагдаж, суптекийг хэрэгжүүлж буй туршлага солилцсон байна. Үүнд:

Хүснэгт. Суптекийг хэрэгжүүлж буй улсууд

№	Улс орон	Зохицуулагч байгууллага
1	Австрали	APRA, ASIC, AUSTRAC
2	Австри	OeNB
3	Бразил	BCB
4	Бруней	AMBD
5	Канад	FINTRAC
6	Бүгд Найрамдах Чех улс	CNB
7	Денмарк	DFSA
8	Европын холбоо	EIOPA
9	Герман	BBk
10	Грек	BoG
11	Гуернсей	GFSC
12	ХонгКонг	HKMA
13	Итали	BoI
14	Йордан	CBJ
15	Кени	CBK
16	Литуана	BoL
17	Малайз	BNM
18	Мексик	BoM, CNBV, CONSAR
19	Нидерланд	DNB
20	Нигер	CBN
21	Перу	SBS
22	Филиппин	BSP
23	Польш	KNF
24	ОХУ	CBR
25	Руанда	BNR
26	Сингапур	MAS
27	Өмнөд Африк	SARB
28	Швейцар	FINMA
29	Тайланд	BOT
30	Их Британи	FCA, BoE
31	АНУ	FRB, FRBNY, SEC, CFPB

Эх сурвалж: BIS

Харин суптекийг нэвтрүүлээд буй 99 зохицуулагч байгууллагаас судалгаа авахад 36 нь хөгжүүлэлтийн, 34 нь туршилтад, 29 нь үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн гэж хариулсан ба суптек санаачилгуудын гуравны нэгээс бага нь үйл ажиллагаа явуулж,

дийлэнх нь туршилтын болон хөгжлийн шатандаа байна. Улс орнуудын туршлагаас харахад олон тооны суптек санаачилгууд нь мэдээллийн технологийн дэд бүтэцтэй нөхцөлд хялбар хэрэгждэг байна. Нээлттэй эх үүсвэр дээрх программууд нь албан хаагчдыг үнэгүй эсвэл зардал багатай ашиглаж санаагаа турших, боломжит кибер аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлстэй танилцах юм. Суптек хөгжүүлэгчдийн дөрөвний гурав нь өөрсдөө, эсвэл их сургуулиудтай хамтран боловсруулсан бол ердөө дөрөвний нэг нь гаднын байгууллагаар боловсруулсан байна. Суптек санаачилгуудын бараг дөрөвний гурав нь байсан эсвэл одоо ч байгаа дотооддоо эсвэл хамтран гадаад хөгжүүлэгчид болон их, дээд сургууль зэрэг байгууллагуудтай хамтран боловсруулсан байна.

Монголбанк нь Солонгосын банк (Солонгосын төв банк)-ны өгөгдөл, статистик хэрэглээний туршлага, мэдлэгт үндэслэн Монголбанкны төвлөрсөн их өгөгдлийн процесс, нэгтгэлийн системийн бодлогоор хангах судалгааг хийж, нэвтрүүлэх аргачлалыг тодорхойлсон.

Солонгосын банк нь их өгөгдлийг нэвтрүүлэх гурван чиг хандлагад үндэслэн нэвтрүүлэх болсон.

1. Өгөгдлийн эдийн засгийн эрин зуун дэлгэрч байна. Их өгөгдлийг төвлөрүүлэх, ашиглах, хиймэл оюун ухаан, машин сургалт дахь өгөгдөлд суурилсан шинэ дижитал технологи, финтек шиг шинэ технологийн хэрэглээний улмаас санхүүгийн зах зээл дэх хурдтай өөрчлөлт нөлөөлж байна.
2. АНУ-ын Нөөцийн банк, Европын холбооны нөөцийн банк, Энэтхэгийн банк, Олон улсын төлбөр тооцооны банкууд шинэчлэл хийж эхэлсэн.
3. Өгөгдөлд суурилсан дижитал шинэчлэлийг хийх солонгосын банкны урт хугацааны стратеги.

Олон улсын төлбөр тооцооны банк (BIS) нь их өгөгдлийг нэвтрүүлэх дунд хугацааны стратегийг боловсруулсан.

Их өгөгдлийн олгож буй боломжоос хамгийн үр дүнтэйгээр ашиглахын тулд хоёр асуудлыг харгалзан үзэх нь маш чухал. Нэгдүгээрт, мэдээллийн технологийн дэд бүтэцтэй холбоотой статистикийн мэдээллийг хэрхэн зохион байгуулах. Хоёрдугаарт, шинээр бий болсон мэдээллийг үнэлэх, ажиллуулах тохиромжтой арга техник ашиглах юм.

Үүний тулд их өгөгдөл/өндөр гүйцэтгэлийн тооцооллын платформыг суурилуулахад архитектур, технологийг сонгохоос өмнө боломжит хувилбаруудыг анхааралтай үнэлэх нь зүйтэй.

Их өгөгдөл/өндөр гүйцэтгэлтэй тооцооллын платформын технологи, архитектурыг сонгоход анхаарах зүйлс:

- Техник хангамжийн сонголт
- Нээлттэй эх сурвалжтай технологи
- Үүлэн суурьт шийдэл
- Тохируулах мэдээллийн төрөл.

Гол сорилтууд:

- I. Шинэ платформ нэвтрүүлэх, үр дүнтэй ашиглах үед боломжит эх үүсвэрийн хязгаарлалт: мэдээллийн технологийн өндөр зардал, олон зарчимт баг бүрдүүлэх хүний нөөцийн саатал, техник талын статистик, шинжилгээ, мэдээллийн технологийн болон өгөгдлөөс үнэ цэнтэй шинэ зүйлийг боловсруулах чадвартай албан хаагчдын эрэлт.
- II. Шинэ төрлийн мэдээлэлтэй харилцах хүндрэл: Их хэмжээний өгөгдөл цуглуулснаар нууцлал, аюулгүй байдлыг хангах шаардлага үүсдэг.

- III. Мэдээллийн технологийн шийдлийн бодит хэрэгжилт: Уян хатан орчныг бүрдүүлэх төвлөрсөн программ хангамж, төрөл бүрийн даалгавар дахь ялгаатай төв (node) дэх төвлөрсөн бус процесс, ялгаатай программын орчныг ашиглах боломж.

Японы төв банкны өргөтгөсөн бизнес тайлагналын хэл /extensible business reporting language–XBRL/: Японы төв банк рүү өгөгдөл илгээдэг санхүүгийн байгууллагууд нь экселээс XBRL рүү хөрвүүлэгчийг компьютер дээрээ суулгадаг. Санхүүгийн байгууллагуудаас бодит цагаар, өдрөөр, давтамжтайгаар авдаг өгөгдлийг экселээс XBRL рүү хөрвүүлж, VPN–ээр дамжин Японы төв банкны өгөгдлийн санд илгээгддэг.

Европын холбооны Даатгал болон Тэтгэврийн сангийн зохицуулалтын хорооны Хяналт шалгалтын процессын даргатай хийсэн ярилцлагад Суптекийг хэрэгжүүлэхэд байгууллагын ба технологийн гэсэн хоёр сорилт тулгардаг гэж дурдсан байдаг. Технологийн хувьд ямар технологид хөрөнгө оруулах, технологийг бүрэн бүрдүүлж, тэдгээр нь ажиллахад бэлэн эсэхэд анхаарахыг зөвлөсөн.



ДУГНЭЛТ, САНАЛ

Эрсдэлийг урьдчилан илрүүлж, тохиолдохоос нь өмнө удирдсанаар санхүүгийн зах зээл, эдийн засагт учрах хохирлыг хамгийн бага түвшинд барьж чадна. Үүнийг хэрэгжүүлэх орчин үеийн чиг хандлага нь технологид суурилсан хяналт шалгалт буюу суптек юм.

Суптекийг хэрэгжүүлж буй нэлээдгүй зохицуулагч байгууллагууд байгаа бөгөөд тэдгээрийн туршлагаас суралцаж, хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдэлээс сэргийлэх боломжтой болжээ. Суптекийг хэрэгжүүлэх урьдач нөхцөл нь сайтар төлөвлөх, албан хаагчид болон оролцогч талуудын хамтын ажиллагаа, чадавхтай хүний нөөц хамгийн чухал хүчин зүйлс болох юм.

Санхүүгийн хяналт шалгалтад суптекийг нэвтрүүлэх нь зайлшгүй шаардлагатай ба дараах хүчин зүйлсийг зайлшгүй бүрдүүлэх шаардлагатай:

- Гуравдагч тал буюу санхүүгийн байгууллагууд, Мэргэжлийн холбоодтой нягт хамтран ажиллах;
- Удирдлагын багаас суптекийг нэвтрүүлэхэд эрсдэлүүд үүсдэгийг ойлгох, мөн дэмжиж ажиллах;
- Хүний нөөцөө бэлтгэх, дата аналитаар мэргэшсэн албан хаагчийг ажиллуулах;
- Үр дүнтэй туршилт явуулах, бүх санааг турших;
- Өгөгдлийн удирдлага болон засаглалыг хэрэгжүүлэх.

Суптекийн Санхүүгийн зохицуулах хороонд нэвтрүүлэх аргууд:

- Зардал, цаг хугацаа хэмнэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх R2A–д хандаж, Санхүүгийн зохицуулах хороонд хэрэгжих суптекийн загварыг гаргах;
- Хүний нөөцийг чадавхжуулах Кембриджийн их сургуулийн суптекийн сургалтад хамрагдах. Үүний тулд Билл ба Миленда Гейтсийн сангаас тэтгэлэг авах ;
- Инновацийн лабораторитой болох.

ЭХ СУРВАЛЖ

- Appaya, Mandepanda Sharmista, et al. "A Roadmap to SupTech Solutions for Low Income (IDA) Countries." (2020). Retrieved from: <https://documents1.worldbank.org/curated/en/108411602047902677/pdf/A-Roadmap-to-SupTech-Solutions-for-Low-Income-IDA-Countries.pdf>
- Bruno, Giuseppe, et al. Computing platforms for big data analytics and artificial intelligence. Bank for International Settlements, 2020. retrieved from https://www.bis.org/ifc/publ/ifc_report_computing_2004.pdf
- Broeders, Dirk, and Jermy Prenio. "Innovative technology in financial supervision (suptech): The experience of early users." FSI Insights on policy implementation 9 (2018).
- Di Castri, Simone, et al. "The suptech generations." Available at SSRN (2019).
- EIOPA. Suptech Strategy. Interview with Ana Teresa Moutinho, Head of Supervisory Processes <https://www.eiopa.europa.eu/media/speeches-presentations/contribution/suptech-strategy>
- Fintech for regulators accelerator, <https://r2accelerator.com/>
- Cambridge Suptech Lab, <https://ccaf.io/suptechlab/>
- IBM, Big data analytics, retrieved from <https://www.ibm.com/analytics/hadoop/big-data-analytics>
- OECD. The use of SupTech to enhance market supervision and integrity. Retrieved from: <https://www.oecd-ilibrary.org/sites/d478df4c-en/index.html?itemId=/content/component/d478df4c-en>
- World Bank. The Next Wave of Suptech Innovation: Suptech Solutions for Market Conduct Supervision. World Bank, 2021. <https://documents1.worldbank.org/curated/en/735871616428497205/pdf/The-Next-Wave-of-Suptech-Innovation-Suptech-Solutions-for-Market-Conduct-Supervision.pdf>
- http://www.finconet.org/FinCoNet-Report-SupTech-Tools_Final.pdf

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Үргэлжэл

Сүүлийн жилүүдэд Азийн улс орнуудын Засгийн газар олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлага, практикийг нэвтрүүлэх хүчин чармайлт гаргасаар ирсэн. Тухайлбал, Төрийн өмчит компанийн санхүүгийн болон санхүүгийн бус зорилго, зорилтуудыг илүү тодорхой болгох, төрийн захиргааны байгууллагуудын өмчлөгчийн хариуцлагыг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг тоон үзүүлэлттэй харьцуулан хэмжих, үнэлэх, төрийн өмчит компанийн бизнесийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн тайлагнал зэрэгт ил тод байдал, хариуцлагыг сайжруулах хууль эрх зүйн зохицуулалтын тогтолцоог бий болгох тал дээр чухал ахиц дэвшлүүд гарсан ба мөн худалдаа, хөрөнгө оруулалтын гэрээнд төрийн өмчит компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах зохицуулалтууд нэмэгдэх болсон талаар судалгааны тайланд дурджээ.

Тухайлбал, төрийн өмчит компанийн мэдээллийн тайлагнал, ил тод байдлыг хангуулах чиглэлээр:



Энэтхэг: Тус улсын Компанийн тухай хуулиар (2013 он) компаниуд жил бүр тайлангаа нийтлэх үүрэгтэй бөгөөд Компанийн засаглалын баримт бичгийг дагаж мөрдөх тухай зааснаас гадна бүх

төрийн өмчит компани Засгийн газраас баталсан ил тод байдлын журмыг дагаж мөрддөг. Компаниуд журмын дагуу төрийн захиргааны байгууллагад тайлангаа улирал тутам хүргүүлэх үүрэгтэй. Үүнд ТУЗ-ийн тайлан, танилцуулга, ээлжит бус хурлын мэдээлэл, жилийн тайлан, гүйцэтгэх удирдлага, хяналтын тогтолцооны гүйцэтгэл болон аудитын дүгнэлтүүд гэх мэт мэдээллүүд багтдаг байна. Эдгээр мэдээллийг төрийн захиргааны байгууллага төрийн өмчийн компанитай үр дүнгийн гэрээ байгуулан, түүний дагуу хянаж, үнэлдэг.



Индонез: 2008 оны холбогдох хууль болон Компанийн сайн засаглалын тухай журам (ТӨК хариуцсан сайдын 2012 оны 9/2012 тоот шийдвэр)-ын дагуу төрийн өмчийн компани зарим

мэдээллийг олон нийтэд мэдээлэх үүрэг хүлээдэг. Сангийн яам болон ТӨК-ийн асуудал хариуцсан яам/эсхүл аль нэг нь мэдээллийн ил тод байдлын гүйцэтгэлийн талаар төрийн эрх барих дээд байгууллага /парламент/-д сонгол хийх үүрэгтэй ба эдгээр яамд болон төрийн өмчийн компани нь өөрийн үндсэн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, ТУЗ-тэй холбоотой мэдээллийг нийтэд мэдээлэх, лавлагаа авах цахим сувагтай байх нөхцөлийг хангасан байна.



Казахстан: Төрийн өмчийн компаниуд Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тухай хуульд заасан тайлагналын шаардлагыг дагаж мөрддөг,

Үндэсний эдийн засгийн яам гүйцэтгэлийн үнэлгээнд нь хяналт тавьдаг ба төрийн өмчийн компаниуд Компанийн засаглалын кодекс (2015он)-ийг дагаж мөрдөх үүрэгтэй.



Бүгд Найрамдах Солонгос Улс: Мэдээллийн ил тод байдлын хууль (1998)-аар төрийн болон олон нийтийн байгууллага, төрийн өмчийн компани үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод болгох

ёстой. Тухайлбал, төрийн бүх байгууллагууд, түүний дотор төрийн өмчийн компани нь “Бүх нийтийн мэдээлэл нэг дор” хэмээх интернэтэд суурилсан платформоор дамжуулан олон нийтэд өөрийн мэдээллийг ил болгож, тайлагнах үүрэгтэй ба үүнд удирдах албан тушаалтан, ажиллагсад, санхүүгийн тайлан, орлого, зарлагын тайлан, аудитын тайлан, хяналт шалгалт, татвар, үнэлгээний тайлан гэх мэт мэдээлэл багтдаг. Уг хуулийн дагуу төрийн өмчийн компанийн гүйцэтгэх захирлыг нэр дэвшүүлж буй хурлын тэмдэглэлийг онцгой тохиолдлоос бусад үед олон нийтэд нээлттэй байлгах, удирдах албан тушаалтны бусдыг залилан мэхлэх, ёс зүйн зөрчил гаргасан гэм буруу нь тогтоогдвол шийтгэл ногдуулж, олон нийтийн хяналтад оруулахыг Эдийн засаг, сангийн сайд, эрх бүхий байгууллагын удирдлагад үүрэг болгосон. Түүнчлэн, ТӨК-ийн салбарт буй жендэрийн цалингийн зөрүүний асуудлыг шийдвэрлэх хүрээнд 2018 оны 12 дугаар сарын 31-ний

өдөр Төрийн байгууллагын удирдлагын тухай хуульд жөндөрийн цалингийн зөрүүг ил тод болгохыг үүрэг болгосон нэмэлт, өөрчлөлтийг оруулж, энэ үүргийг дагаж мөрдөөгүй, эсхүл санаатайгаар худал мэдээлэл гаргасан тохиолдолд торгууль ногдуулахаар зохицуулжээ.



Малайз: Олон нийтэд нээлттэй төрийн өмчийн компани нь Хөрөнгийн бирж (Malaysia Securities Berhad)-ийн бүртгэлийн нөхцөл, шаардлагыг дагаж мөрддөг. Энэхүү бүртгэлийн нөхцөл, шаардлагын дагуу санхүүгийн бус мэдээлэл гэдэгт компанийн удирдлагын өөрчлөлт, зээл, үнэт цаас худалдан авахтай холбоотой тендер санал зэрэг мэдээлэл ордог байна.



Пакистан: Компанийн засаглалын дүрэм (2013 он)-ээр төрийн өмчийн компаниуд санхүүгийн мэдээллийг олон улсын санхүүгийн тайлагналын стандартын дагуу ил тод болгох үүргийг хүлээж, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, тэдгээрийн бие даасан хараат бус байдлын дүрэмтэй байхыг шаарддаг.



Филиппин: Тус улсын төрийн өмчийн компаниуд нь зохицуулагч байгууллагаас баталсан мэдээллийн ил тод байдлын шаардлагыг дагаж мөрддөг бөгөөд түүнд цахим хуудсыг хөгжүүлэх, санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг байршуулахаар заасан байна. Үнэт цаасны зохицуулагч компанийн засаглалыг бэхжүүлэх зорилгоор 2019 онд Корпорацийн кодексийг шинэчлэн баталсан ба улмаар компаниуд эцсийн өмчлөгчөө ил тод болгохыг үүрэгжүүлсэн.



Тайланд: Засгийн газрын 2011 оны шийдвэрээр бүх компаниуд хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын нэгэн адил мэдээллийг ил тод болгох шаардлагыг тавьсан. Төрийн эрх бүхий байгууллагаас төрийн өмчийн компанийн салбарын тоймыг жил бүр нийтэлдэг бөгөөд энэхүү тайлан нь төрийн бодлогын хэрэгжилтийн нөхцөл байдал, санхүүгийн харьцаа, гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтийн талаарх мэдээллийг агуулсан байдаг. Төрийн өмчийн компанийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг төрийн эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан үзэж үнэлдэг.



Вьетнам: Төрийн өмчийн компанид тавигдах шаардлага (2015)-ын дагуу жилийн болон хоёр жилийн санхүүгийн тайлан, таван жилийн бизнесийн стратеги төлөвлөгөө, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэл, цалин урамшуулал, орлогын тайланг нийтлэх үүрэг хүлээдэг. Төрийн өмчийн компани аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа төрийн эрх бүхий байгууллагад хүргүүлэхийн өмнө өөрийн цахим хуудсанд байршуулах үүрэгтэй. Гэвч бодит байдал дээр төрийн өмчийн компаниуд мэдээллийн ил тод байдлын шаардлагыг дагаж мөрдөх байдал хангалтгүй байгаа аж.

Үргэлжлэл бий...

Эх сурвалж: www.adb.org



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ГЭЖ ЮУ ВЭ?



Хөрөнгө оруулалтын сан нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг мэргэжлийн түвшинд судалгаа хийж, хөрөнгө оруулалтын шийдвэрт үндэслэн үнэт цаас худалдан авах замаар өсгөдөг.

ХЭЛБЭР



Хамтын хөрөнгө оруулалтын сан

Олон нийтэд санал болгож хөрөнгө татан төвлөрүүлдэг



Хувийн хөрөнгө оруулалтын сан

Цөөн тооны хүнд санал болгож хөрөнгө татан төвлөрүүлдэг

ТӨРӨЛ



Нээлттэй

Сан үүсгэн байгуулагдсанаас хойш нэгж эрхийг худалдаж, худалдан авах боломжтой



Хаалттай

Сан үүсгэн байгуулагдсанаас эхлээд татан буугдах хүртэл хугацаанд нэгж эрхийг худалдаж, худалдан авах эрх хязгаарлагдмал

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН



Хөрөнгө оруулалтын сан нь хадгаламжийн хүүнээс өндөр өгөөж хүртэх боломжтой ба хувьцаа, бонд худалдах авах судалгаа, шинжилгээ хийх таны цагийг хэмнэдэг.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР




САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Цуврал №23

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

ЭРСДЭЛ БА ӨГӨӨЖИЙН ТҮВШИН



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



НАЙДВАРТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГ СОНГОХОД АНХААРАХ ЗҮЙЛС:

- 1 Тусгай зөвшөөрөлтэй хөрөнгө оруулалтын компанийг сонгох;
- 2 Нэгж эрхийн танилцуулгыг сайтар судалж, таны хөрөнгө оруулалтын зорилгод нийцэж буйд анхаарах;
- 3 Хөрөнгө оруулах хөрөнгийн хэмжээг сайтар тооцох;
- 4 Танд санал болгож буй өгөөжийн хувь, шимтгэлийг тооцоолох;
- 5 Гэрээний нөхцөлүүдийг уншиж, танилцах.

Тусгай зөвшөөрөлтэй хөрөнгө оруулалтын компанийн мэдээллийг дараах QR кодыг уншуулан авна уу.



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР


ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

“ЭМЭГТЭЙЧҮҮД–БИЗНЕС БА ЭРХ ЗҮЙ” 2023 ТАЙЛАН ГАРЛАА

Дэлхийн 190 орны эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн орчны үзүүлэлтээр Монгол улс 90.6 оноо авч Болгар, Румын улсуудтай ижил үнэлэгдэв. Дэлхийн банкнаас ижил бүр гаргадаг “Эмэгтэйчүүд–Бизнес ба Эрх зүй 2023” судалгааны тайланд:

2022 онд 18 улс орон жендерийн тэгш байдлыг хангахтай холбоотой 34 эрх зүйн шинэчлэлийг хийсэн. Үүнд Монгол улсад хийгдсэн дараах шинэчлэлүүд багтсан байна.

- Шинээр төрсөн хүүхдээ асрах аавуудад ажлын 10–аас доошгүй өдрийн цалинтай чөлөөг олгох;
- Ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх.



БНХАУ 2023 ОНД ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ 5 ХУВЬД ХҮРГЭХ ЗОРИЛТ ТАВИЛАА



БНХАУ–ын Бээжин хотод 2023 оны 03 дугаар сарын 5–ны өдрөөс 14 дэх удаагийн Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хуралын хуралдаан эхэллээ.

Энэ удаагийн хуралдаанд 3000 гаруй төлөөлөгчид оролцож БНХАУ–ын Төрийн зөвлөлийн шинэ бүрэлдэхүүнийг баталсан байна.

БНХАУ энэ онд эдийн засгийн өсөлтөө 5 хувьд хүргэх, төсвийн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувьтай тэнцүүлэх зорилт тавьсан ба батлан хамгаалахын төсвөө 2019 оноос хойших хамгийн өндөр дүнгээр буюу 7.2 хувиар нэмэгдүүлэхээ мэдэгдсэн байна.

www.financialtimes.com

ХОЛБООНЫ НӨӨЦИЙН БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ 0.25 НЭГЖ ХУВИАР ӨСГӨЖ, 5 ХУВЬД ХҮРГЭВ




АНУ-ын Холбооны Нөөцийн банкны Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 0.25 нэгж хувиар өсгөж 5 хувьд хүргэсэн нь 2007 оноос хойш дээд түвшний үзүүлэлт юм. Холбооны нөөцийн банкны мэдэгдсэнээр 9 удаа дараалан бодлогын хүүг өсгөсөн нь инфляцыг бууруулах, банкны системийн хямралыг гүнзгийрүүлэхгүй гэсэн хүлээлттэй байгаа юм. АНУ-ын төв банк хоёр удаа дараалан бодлогын хүүг 0.25 нэгж хувиар өсгөсөн ба цаашид үнийн өсөлтийг эргэн тогтворжуулахын тулд шаардлагатай бүх арга хэмжээ авахаа мэдэгдсэн байна.

www.bloomberg.com

ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ СААРАХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-аас жил бүр гаргадаг дэлхийн худалдааны таамаглалын тайланд 2023 оны 1-р улиралд дэлхийн худалдаа 1 хувиар өснө гэж таамаглажээ. Мөн дэлхийн эдийн засгийн нөхцөл тааруу байгаа нь 2023 онд дэлхийн худалдааны өсөлт саарах төлөвтэй байгааг онцолжээ.



2022 онд 1-р хагаст дэлхийн худалдааны эргэлт 32 их наяд ам.доллар давснаар дээд түвшиндээ хүрсэн ч 2-р хагаст худалдааны өсөлт саарч, IV улиралд өмнөх оны мөн үеэс 250 тэрбум ам.доллараар буурсан байна.

www.unctad.org

ОУВС УКРАИНД 15.6 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫН ЗЭЭЛ ОЛГОХ САНАЛЫГ ДЭМЖЛЭЭ



ОУВС болон Украины эрх баригчид 15.6 тэрбум ам.долларын зээл олгохоор ажлын хэсгийн түвшинд тохирлоо. Ингэснээр ОУВС 77 жилийн түүхэнд анх удаа дайн болж буй улсад санхүүжилт олгохоор болж буй юм.

Хөтөлбөрийг II үе шаттай явуулах бөгөөд эхний шатанд Украин улсын төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангах бодлого хэрэгжүүлэх, хоёр дахь шатанд Украины сэргээн босголт, макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжихэд чиглэсэн ажлуудыг хэрэгжүүлэх юм.


www.imf.org

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр


S&P 500 /^GSPC/

3,970.99 +22.27 (+0.56%)




Nikkei 225 /^N225/

27,476.87 +91.62 (+0.33%)




FTSE 100 /^FTSE/

7,437.96 +33.18 (+0.45%)



NASDAQ Composite (^IXIC)

11,823.96 +36.56 (+0.31%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia